

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОДБАЯР

**УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 12-Р ХОРОО, МОРИНГИЙН АВТО  
ЗАМААС ЛАНДФИЛИЙН ТАЛБАЙ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН БАРИЛГЫН  
АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

<b>1.Ерөнхий зүйл</b>	Морингийн авто замаас Ландфилийн талбай хүртэл 1.54 км авто зам /ХУД, 12 дугаар хороо/-ын барилга угсралтын ажил хийгдэнэ. Гудамж замын ангилал: Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
<b>2.Барилгын талбайн үзүүлэлт</b>	Авто замын барилгын ажил хийгдэнэ.
<b>3.Ажлын цар хүрээ</b>	<p>Одоо байгаа авто замын трасс нь шороон зам бөгөөд төлөвлөгдөж буй авто зам нь 2 эгнээ, 7м өргөн зорчих хэсэгтэй, 2 талдаа 1.5м явган хүний зам, 2 талдаа 1.0 м тусгаарлах зурвас бүхий ногоон байгууламжтай нийт 13.68м өргөнтэй. Авто замын хучилтын хийц нь дараах хийцтэй байхаар төлөвлөгдсөн байна.</p> <ul style="list-style-type: none"><li>- Өнгө асфальтбетон хучилт -3см</li><li>- Суурь асфальтбетон хучилт -4см</li><li>- Буталсан чулуун суурь -20см</li><li>- Суурийн доод үе -25см</li><li>- Далангийн дүүргэлт</li></ul> <p>Явган замын хийц:</p> <ul style="list-style-type: none"><li>- Өнгөт хавтан -6см</li><li>- Элс цементийн багсармал -4см</li><li>- Зохист ширхэгтэй хайрган суурь -10см</li><li>- Далангийн дүүргэлт</li></ul> <p>Ус зайлуулах байгууламж</p> <p>Авто замын хойд хэсэгт шуудуу төлөвлөсөн. Гадаргуун ус зайлуулалтыг авто замын нүхтэй хашлагаар гаргах бөгөөд бетон бэхэлгээний ажлууд хийгдэнэ.</p> <p>Цахилгаан, гэрэлтүүлгийн шугам сүлжээг батлагдсан зураг төслийн дагуу хийх.</p> <p>Зам барилгын үе шатны ажил:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Барилгын ажил эхлэх зөвшөөрлийг холбогдох газраас албан ёсоор авсан байна.</li><li>2. Барилгын ажлын улаан шугам хүлээлцэж акт үйлдэнэ.</li><li>3. Барилгын ажил эхлэхээс өмнө инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагуудаар барилгын ажлын</li></ol>

	<p>талбай дээр тодруулга хийлгэж нэгдсэн жагсаалтын хуудсаар баталгаажуулсан байх.</p> <p>4. Ажил гүйцэтгэх зураг төслийг батлуулсны дараа ажлын зураг, төлөвлөгөө, заавар, аргачлал, техникийн шаардлагын дагуу барилгын ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.</p> <p>5. Батлагдсан зураг төслийн дагуу инженерийн шугам сүлжээ шилжүүлэх ажлууд хийгдэх</p> <p>6. Зам барилгын бэлтгэл ажил хийгдэх</p>
<b>4.Ажлын хил хязгаар</b>	<p>Зам тээврийн хөгжлийн төвийн 2024 оны 05 сарын 02-ны өдрийн 115/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан инженерийн нарийвчилсан зураг төслийн дагуу барилга угсралтын ажлыг хэрэгжүүлнэ.</p>
<b>5.Барилгын ажлын зохион байгуулалт</b>	<p>1) Гүйцэтгэгч гэрээ байгуулсны дараа ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн дагуу зөвшөөрөл авна.</p> <p>2) Захиалагч барилгын ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх ба өгснөөс хойш ашиглалтад оруулах хүртэл хугацаанд ажлын талбайг эзэмших эрхийг захиалагч бичгээр баталгаажуулна. Энэ хугацаанд гүйцэтгэгч нь аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p> <p>3) Гүйцэтгэгч нь газар доорх болон дээрх инженерийн шугам сүлжээг чөлөөлөх, шилжүүлэх, хамгаалах ажлыг хариуцна. Үүнд: цахилгаан, борооны ус зайлуулах байгууламж болон гэрэлтүүлгийн шугам гэх мэт. Энэ ажилтай холбоотой гарах бүх зардлыг гүйцэтгэгч хариуцна.</p> <p>4) Барилга угсралтын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг тэмдэглэгээ г.м/-ыг бүрэн хангаж ажиллана.</p> <p>5) Ажил гүйцэтгэх үедээ карьер нээх, хог хаягдал хаях төвлөрсөн цэг нээх зэрэг ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлуудын талаар харьяалах дүүргийн засаг захиргааны удирдах албаны ажилтнууд болон байгаль орчны байцаагчидтай харилцан зөвшилцөж ажиллана.</p> <p>6) Тухайн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр бусад төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч, хүн хүч, машин, механизмийн хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>7) Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байршуулна. Ажлыг батлагдсан төлөвлөгөө, аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна. Ажлыг гүйцэтгэхдээ өөрийн гүйцэтгэж байгаа</p>

	<p>ажил, явганаар зорчиж байгаа ард иргэдэд бэрхшээл учруулахгүй байх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, түр зам гаргаж байнгын арчилгаатай байлган оршин суугчдын ая тухтай зорчих байдлыг ханган ажиллаж, зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай. НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар баталсан “Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага”-ыг баримтлан гүйцэтгэнэ. Ингэхдээ итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэн чанартай, шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>8) Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>9) Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баримтжуулаагүй, 7 хоног тутмын тайланд тусгагдаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар зэргийг ашиглана. Нөгөө талаас холбогдох БНБД-үүд, техник технологийн стандартуудад заасан шаардлагуудыг хангаж ажиллахыг анхаарна уу.</p> <p>10) Барилгын ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрт бэлтгэсэн түүхий эд, материал хэрэглэх бөгөөд захиалагч байгууллагаас зөвшөөрөл авсан үндсэн дээр гэрээ байгуулна.</p>
<p><b>6.Бусад</b></p>	<p>Авто замын барилгын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.</p>

Морингийн авто замаас Ландфилийн талбай хүртэл 1.54 км авто зам /ХУД, 12 дугаар хороо/-ын барилга угсралтын ажлын тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай инженер техникийн ажилтан

№	Албан тушаал	Боловсрол мэргэжлийн ур чадвар	Хүний тоо	Ажлын туршлага /жил/
1	Ерөнхий инженер	Авто замын инженер	1	5 болон түүнээс дээш
1	Авто замын инженер	Авто замын инженер	1	3 болон түүнээс дээш
2	Геодезийн инженер	Геодезийн инженер эсвэл авто замын инженер	1	2 болон түүнээс дээш
3	Материалын инженер	Авто замын инженер (материалын инженер чиглэлээр ажилласан туршлагатай)	1	2 болон түүнээс дээш
4	Хөдөлмөр хамгааллын инженер	(ХАБЭА сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх)	1	1 болон түүнээс дээш
5	Хөдөлгөөн зохион байгуулалтын инженер	Зам, тээврийн хөдөлгөөн зохион байгуулалтын инженер эсвэл тээврийн менежмент эсвэл авто замын инженер	1	2 болон түүнээс дээш

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай машин механизмууд**

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Автогрейдер	шр	1	175 м.х -с дээш	Өөрийн болон түрээс
2	Усны машин	шр	1	5 тн -с дээш	Өөрийн
3	Экскаватор	шр	1	1.5 м3	Өөрийн болон түрээс
4	Ачааны автомашин	шр	3	15 тн	Өөрийн
5	Авто ачигч	шр	2	1.5 – 2 м3	Өөрийн
6	Индүү /доргиурт/	шр	2	17 – 20 тн	Өөрийн болон түрээс
7	Хийн дугуйт индүү	шр	1	14 – 16 тн,	Өөрийн болон түрээс
8	Индүү /гөлгөр булт/	шр	2	13-16 тн	Өөрийн болон түрээс
9	Пикап	шр	1	1,5-5 тн	Өөрийн
10	Асфальтбетон дэвсэгч	шр	1	/өргөний хэмжээ 3.5-7м/	Өөрийн болон түрээс

11	Автогудронатор	шр	1	3000л-с дээш	Өөрийн болон түрээс
12	Хогийн сав	ш	1	18тн	Өөрийн

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай  
тоног төхөөрөмжүүд:**


№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Компрессор	шр	1	110 м.х	Өөрийн
2	Нүүдлийн цахилгаан үүсгүүр	шр	1	30 квт -аас багагүй	Өөрийн
3	Зөөврийн гагнуурын аппарат	шр	1	500 а	Өөрийн
4	Гар нягтруулагч	шр	1		Өөрийн
5	Шөнийн цагт ажиллахад ашиглах талбайн гэрэлтүүлэг	шр	2		Өөрийн болон түрээс
6	Замын хашлага тавих хайч /босоо, хэвтээ/	шр	8		Өөрийн
7	Гэрэл ойлгогчтой зөөврийн түмбэ, замын хаалт, зөөврийн тэмдэг, тууз, угсардаг хашаа			1540м уртад	
8	Автомат нивелир, теодолит /сүүлийн үеийн/	шр	1		Өөрийн
9	Талбайн дээрх ажлыг фото зургаар баталгаажуулхад шаардагдах багаж хэрэгсэл /Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага 2017-д тусгагдсан/	ком	1		Өөрийн
10	Нийтэд мэдээлэх самбар /2*3 /	шр	2		<u>Өөрийн</u>

**Хянасан:**

Нийслэлийн Замын хөгжлийн газрын  
Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

**Боловсруулсан:**

Нийслэлийн Замын хөгжлийн газрын  
БТХ-ийн мэргэжилтэн



В.Мягмар



М.Ичинхорлоо